



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/198

Мандалговь

Төсөл санхүүжүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.13 дахь заалт, Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 02 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2020-2024 үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.1.8, 5.1.4.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн дулаарал, цаг агаарын өөрчлөлт, газрын доройтол, цөлжилт, хуурайшилтын эсрэг модны экологи, эдийн засгийн үнэ цэнийг иргэдэд ойлгуулан, экологийн боловсролыг дээшлүүлэх замаар аймгийн хэмжээнд "8 ТҮМЭН МОД" тарих ХӨДӨЛГӨӨН-ийг өрнүүлэн мод тарьж, усалж, арчлан ургуулах мэдлэг, дадлага олгох зорилгоор зохион байгуулагдаж байгаа "Дундговь ноогооруулья" төслийг 2021 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих "Хүнсний ногоо, ногоон байгууламж эрхлэгчдийг чадавхжуулах сургалтын хөтөлбөр"-өөс санхүүжүүлж, санхүүжилтийн задаргааг хавсралтаар баталсугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө, оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Б.Мөнхжаргал), Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (Н.Гантулга), Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210543